



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

169 /169/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.02

ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА-УУЛЗАЛТ БОЛЛОО



2022 оны төсвийн танилцуулга ээлжит уулзалтад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нар оролцож, салбарын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, ирэх оны төсвийн төслөө танилцууллаа. Мөн Батлан хамгаалах, эрчим хүч, соёлын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын явцын талаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ РАДИОТЕХНИКИЙН ИНЖЕНЕРҮҮД, ТУСГАЙ САЛБАРУУДЫН ТЕХНИК ХАРИУЦСАН ОРЛОГЧ НАРЫН ЦУГЛАРАЛТ БОЛЛОО



Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас агаарын цэргийн ангиудын радиотехникийн инженерүүд, тусгай ротын захирагчийн зэвсэг, техник хариуцсан орлогч нарын цугларалтыг 10 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Агаарын цэрэг нь "Зэвсэгт хүчний тухай хууль"-иар Монгол Улсын агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах үндсэн үүрэгтэй. Энэ хүндтэй бөгөөд өндөр хариуцлагатай үүргийг үе үеийн агаарын цэргийн алба хаагчид нэр төртэй гүйцэтгэж ирсэн. Өнөөдөр ч тайван цагт байлдааны жижүүрлэлтийн үүргийг манай цэргийн алба хаагчид өндөр хүчин чадалтай техник хэрэгслийн тусламжтайгаар 24 цагийн турш тасралтгүй гүйцэтгэж улсын агаарын орон зайд цаг мөч алдалгүй хяналт үйлдэж байна. Энэхүү чухал үүргийг амжилттай гүйцэтгэхийн гол үндэс нь

техникийн бэлэн байдал, тэдгээрийн найдвартай ажиллагаа бөгөөд энэ асуудлыг Зэвсэгт хүчний агаарын цэргийн ангиудын радиотехникийн инженер, тусгай салбаруудын захирагчийн зэвсэглэл техник хариуцсан орлогч нар хариуцан ажиллаж зэвсэглэл техникийн үзлэг, хуваарьт техникийн үйлчилгээг явуулж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд гэмтлийг яаралтай оношлон засварлаж хэвийн ажиллагаанд оруулан ажилладаг. Хариуцлагатай энэ ажил албыг хашиж байгаа тэдэнд чиглэгдсэн цугларалтыг зохион байгуулах нь маш чухал ач холбогдолтой бөгөөд энэ төрлийн цугларалтыг хамгийн сүүлд 10 гаруй жилийн өмнө зохион байгуулсан юм. Энэ удаагийн цугларалтын гол зорилго нь Радиотехникийн инженер техникийн бүрэлдэхүүний онол,

дадлагын мэдлэгийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, инженер техникийн ажилтнуудын залгамж халааг бэлтгэх, УБХИС-ийг радиотехникийн инженерээр төгссөн боловсон хүчнийг инженер чиглэлээр нь тууштай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх юм. Тусцугларалт нь "Радиотехникийн анги, салбаруудын тусгай зориулалтын техникуудийн ашиглалт, чанар байдлыг дээшлүүлэх аргачлалыг боловсронгуй болгох нь" сэдвийн хүрээнд онол, дадлагын хэлбэрээр дөрвөн ангийн байрлалд нэгэн зэрэг хоёр үе шаттайгаар явагдаж агаарын цэргийн анги, тусгай салбаруудын 40 гаруй цэргийн алба хаагч оролцсон юм. Олон жил ажилласан туршлагатай инженерүүд залуу үеийн инженерүүдээ сурган дадлагажуулахад ихээхэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Техник, технологийн дэвшил өдрөөс өдөрт улам хүчирхэгжиж хурдацтай хөгжсөөр байгаа энэ цаг үед техникийн шинэчлэлийг цаг алдалгүй хийх шаардлагатай тулгарч байгаа. Манай инженерүүд үндсэн зэвсэглэлд ашиглагдаж байгаа техникуудийг ямар нэгэн алдаа мадаггүй хэвийн ажиллуулж байнгын бэлэн байдлыг хангасаар байгаа нь тэдний мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн дадлага туршлагын үр дүн юм. Түүнчлэн өөрсдийн нөөц боломжоо ашиглан орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан "Цуурай", "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж" гэх мэт төслүүдийг санаачлан амжилттай хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Эх орныхоо цэлмэг хөх тэнгэрийг нүд цавчилгүй харуулах агаарын цэргийн алба хаагчдын үйлс өөдөө байг.

Хошууч Э.ОЧБАДРАХ

Түүхэнд энэ өдөр

1921 он.
Хүрээнд Анхны бага сургууль байгуулагдав.



ЦАГ АГААР

| УЛААНБААТАР | |
|-------------|--------|
| ӨДӨР | ШӨНӨ |
| ☀️ 3 | ☁️ -13 |
| ӨМНӨД СУДАН | |
| ӨДӨР | ШӨНӨ |
| ☀️ 35 | ☁️ 24 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|---------|---------|
| USD 🇺🇸 | 2,849.0 | 2,852.0 |
| EUR 🇪🇺 | 3,300.0 | 3,315.0 |
| CNY 🇨🇳 | 444.50 | 446.00 |
| RUB 🇷🇺 | 40.50 | 41.20 |
| JPY 🇯🇵 | 25.95 | 25.20 |
| KRW 🇰🇷 | 2.39 | 2.40 |

ЗУРХАЙ

2021.11.02 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЫН 27/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН НАЙМАН ЦАГААН ХӨХ БАР ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.38-17.33
Бариуллага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал:
Төмөр

Аргын тооллын 11 сарын 2, Ангараг гараг. Билгийн тооллын 27, Тугчин одтой, хөх бар өдөр. Өдрийн наран 7 цаг 38 минутад мандан, 17 цаг 33 минутад жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэтгэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|----------------------------------|---------------------|-------------------------|
| НИЙТ БҮРТГЭГДСЭН 354,512 +921 | ЭДГЭРСЭН 533,468 | НАС БАРСАН 1,621 +11 |
|----------------------------------|---------------------|-------------------------|

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| | | |
|------------------------------|----------------------------|------------------|
| НИЙТ БАТЛАГДСАН 6071 +105 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 176 | ЭДГЭРСЭН 5777 |
|------------------------------|----------------------------|------------------|

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

| |
|--------------------------------|
| Тохиолдол Нийт: 246,025,709 |
| Эдгэрсэн Нийт: 222,857,225 |
| Нас барсан Нийт: 4,989,532 |

ЦАХИМ ШУУДАНД

Сургалт бэлтгэл

“АЛДАР” СПОРТ ХОРООНЫ ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Батлан хамгаалах байруудад шалгарсан нь яамны харьяа, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны 2021-2022 оны сургуулийн жилийн нээлт боллоо. Нээлтэд Батлан хамгаалах яамны ТЗУГ-ын байруудад шалгарсан нь та бүгдийн ажлын үзүүлэлт юм” гэв. Спорт хорооныхоо амжилт, алдаа оноог дүгнэсний дараагаар хурандаа Г.Өсөхбаяр 2021-2022 оны сургуулийн зорилтуудад тусгасан байна. Мөн энэ үеэр хурандаа С.Ванчинхүү Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайн мэндчилгээг бие бүрэлдэхүүнд уншиж



дарга, хурандаа С.Ванчинхүү оролцов. “Алдар” спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр нээж хэлсэн үгэндээ “Өнгөрсөн сургуулийн жилд бид таван зорилт дэвшүүлэн сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа. Алдар спорт хорооны хувьд өнгөрч буй сургуулийн жилд спортын 18 төрлийн баг тамирчид биеийн тамир, спортын газрын төлөвлөгөөний дагуу бүх шатны 21 уралдаан тэмцээнд давхардсан тоогоор 85 тамирчин амжилттай оролцож 38 алт, 39 мөнгө, 29 хүрэл нийт 106 медаль хүртсэн амжилт гаргалаа. Оролцсон бүх тэмцээндээ багийн дүнгээр тэргүүн, дэд

жилд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх арга замын хамт танилцуулан, нийт бие бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өглөө.

“Алдар” спорт хороо нь дан ганц спортын бус монголын нийт хүүхэд залууст нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зэрэг нийгэмд чухал үүрэг хүлээсэн байгууллага юм. Энэ чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлууд болон цэргийн алба зохион байгуулалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, сахилга бат, цаг ашиглалт, нийт алба хаагч, ажилчдын ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг нэмэгдүүлэх, спортын амжилтыг бататгах, ахиулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг дээрх

танилцуулсны дараагаар “Алдар” спорт хорооны удирдлагуудын хамтаар зарим алба хаагчдад албан тушаалын зэрэглэлийн цол олгогдсоныг гардуулан өгсөн юм.

Өнгөрөгч сургуулийн жилийн хувьд дэлхий нийтийг хамраад буй цар тахлын уршгаар уралдаан тэмцээний тоо өмнөх оны сургуулийн жилийнхтэй харьцуулахад 8 дахин буурсан ч нэг тэмцээнд ноогдох медалийн чанар 4 хувийн өсөлттэй гарсан аж. Түүнчлэн Их болон Үндэсний спортын төрөлд оруулсан хувь нэмрийг үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гавьяат тамирчин цол тэмдгээр 4 алба хаагч, нэг ахмад тамирчин шагнагджээ.



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

АНГИЙН “ЦАХИМ ГҮЙЛТ” НЭГ САРЫН АЯНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Монгол Улс “Цахим үндэстэн” болох уриалгыг дэмжих, “Зэвсэгт хүчний ахлагчийн албаны бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан ангийн бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор ангийн ахлагчийн зөвлөлөөс “Цахим гүйлт” нэг сарын аяныг 2021 оны 9 дүгээр сарын 27-оос 10 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл зохион байгууллаа.

Аянд 120 офицер, ахлагч, ажилчин албан хаагч хамрагдаж, нийт 7614 км замыг туулсан. Аянд дараах бүрэлдэхүүн идэвхтэй хамрагдаж шагналт байруудад шалгарлаа. Тодруулбал, эрэгтэй 18-35 насны ангилалд I байрыг цэргийн цагдаагийн ротын дэд ахлагч Б.Даваажав 362 км, II байрыг нэгдсэн агуулахын харуулчин, ахлагч Т.Мөнхмандал 232 км, III байрыг ахлагч Б.Тулга 198 км. Эрэгтэй 36-аас дээш насны ангилалд I байрыг нэгдсэн агуулахын харуулчин, ахлах ахлагч Ц.Батжаргал 447 км, II байрыг ажиллагааны ахлагч, сургагч ахлагч Б.Ганбаяр 384 км, III байрыг цэргийн цагдаагийн ротын ахлах ахлагч З.Батжаргал 201 км.

Эмэгтэй цэргийн алба хаагчдын ангилалд I байрыг сувилагч, дэд ахлагч Ш.Эрдэнэчимэг 374 км, II байрыг сэтгэл зүйн хангалтын офицер, ахлах дэслэгч Т.Дэлгэрмаа 291 км, III байрыг цэргийн цагдаагийн ротын дэд ахлагч Х.Баярмаа 101 км. Эмэгтэй ангийн ажилчин албан хаагчдын ангилалд I байрыг н.Мөнхбаясгалан 338 км, II байрыг сувилагч Т.Амаржаргал 237 км, III байрыг Б.Энхтуяа 159 км-ын амжилтаар хамт олноо тэргүүлэн алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, цалинтай хоногийн чөлөөгөөр шагнууллаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

Нээлтийн ажиллагааг морин хуурийн аялгуугаар нээж, ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр, салааны захирагч, дэслэгч Б.Энхманлай, шинэ дайчдыг төлөөлж байлдагч Б.Шижирболд нар үг хэлж, цэргийн цол олгох тухай ангийн захирагчийн тушаалаар дэд ахлагч О.Гүен, Х.Баярмаа нарт албан тушаалын ахлагч цолыг олголоо. Мөн “Цахим гүйлт”



нэг сарын аяны шилдгүүдийн шагнал урамшууллыг гардуулан, ахлах ахлагч Я.Бямбасүрэн “Дандар баатар” дугаар ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүлээ.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГЫН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙН ШИЛДЭГ ЛОГО ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ



Уралдааны зорилго: Монголын мэргэжлийн урлагийн ууган байгууллага болох Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын 2022 онд тохиох түүхт 90 жилийн ойд зориулсан брэнд логог шалгаруулж, цаашид ойн хүрээнд зохион байгуулагдах бүхий л үйл ажиллагаа, тоглолт, уран бүтээлүүд, реклам зар сурталчилгаа зэрэг төрөл бүрийн хэлбэрээр ашиглахад оршино.

Уралдааны хамрах хүрээ: Уран зураг, график дизайны чиглэлээр их, дээд сургуульд суралцагчид, лого бүтээгч аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн оролцох боломжтой.

Хугацаа: Уралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд хүлээн авч, 2021

оны 11 дүгээр сарын 14-ний өдөр шилдэг логог 1 үе шаттайгаар шалгаруулна.

Ерөнхий шаардлага: Уралдаанд ирүүлж буй бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын түүх, үйл ажиллагааны онцлогийг тодотгон харуулсан байх, /Энэ талаарх мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон БХЯ-ны вэб сайтаас авах боломжтой/
- ЦДБЭЧ-ын уламжлал, шинэчлэлийн утга санааг бэлгэдсэн элемент агуулсан байх,
- 90 жилийн ойн тоог дүрсэлсэн байх,
- Өнгө, зүй зохицол хосолсон өргөн агуулгатай байх,
- Олон нийтэд ойлгомжтой, утга агуулга нь танигдахуйц байх,
- Хүний анхаарлыг эергээр шууд татах, өвөрмөц дизайны загвартай байж болно.
- Лого нь олон төрлөөр ашиглагдаж, брэндинг хөгжүүлэлт хийх боломж бүхий бүтээл байна.

Тусгай шаардлага: Лого нь видео, сурталчилгааны самбар, сонин сэтгүүл, ил захидал, зурагт хуудас, даавуун болон бусад материалууд, хар, цагаан, өнгөт гадаргуу дээр хэвлэгдэх боломжтой байх,

-Adobe Photoshop, In Design, Corel Draw, Adobe

illustrator зэрэг мэргэжлийн, зориулалтын программ дээр бүтээгдсэн байх,

- Логоны дизайн нь голлох өнгөний дагуу зохимжтой харагдахуйц байх ба жижгээс том хүртэл хэмжээг өөрчилж болохоор зохиох,
- Лого нь өндөр нягтралтай (600 pixels/inch-с дээш) байх,
- Логоны файлын өргөтгөл нь JPG, PDF-ээр байх,
- Логог эх бэлтгэлийн программ дээр бэлтгэхдээ өнгөний тохиргоог CMYK-ээр хийсэн байна.

Логоны зураглалд тавигдах шаардлага: Логоны зураглал бүр нь тодорхой утга санааг агуулсан өнгөний зохицолтой байх ба тэдгээрийг дараах шаардлагын дагуу тайлбарлаж бичсэн байх,

А. “ТАЙЛБАР” гэж гарчилах,

Б. Логоны зүйл бүрийг дугаарлах (1, 2, 3 ...) гэх мэт,

В. Дугаарласан зүйлийн утга, бэлгэдлийг товч, тодорхой, найруулга зүйн алдаагүй, зөв бичгийн дүрмийн дагуу бичсэн байх,

Г. Тайлбар дууссаны дараагаар оролцогч овог нэр, холбоо барих дугаар, цахим хаягийг тодорхой бичсэн байх.

Бүтээлд хориглох зүйл:

- Логог том жижиг олон хэлбэрээр ашиглах тул хэт нарийн зураас болон хэт жижиг дүрс ашиглахгүй байх,
- Урлагийн хэт уран сэтгэмж, тодорхой танигдах

дүрсгүй бүтээл ирүүлэхгүй байх,

- Садар самууныг сурталчилсан утга, өнгөний бэлгэдэлтэй бүтээл ирүүлэхгүй байх,
- Олонд танигдсан өргөн ашигладаг логотой төстэй бүтээл ирүүлэхгүй байх,
- Зохиогчийн эрхтэй, бусдаас хуулбарласан, удирдамжид заасан шаардлагыг хангаагүй бүтээл ирүүлэхгүй байх.

Бүтээл хүлээн авах: Уралдаанд оролцох бүтээлийг tsergiinchulga.1932@gmail.com цахим хаягаар эх файлаар ирүүлнэ.

Уралдааны шалгаруулалт: Удирдамжид заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгаж, бүтээлийг бүртгэж зохион байгуулагчдын зүгээс томилогдсон шүүгчдийн баг оноо өгөх системээр шилдэг 1 бүтээлийг шалгаруулна.

Зохиогчийн эрх:

- Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг буцааж олгохгүй бөгөөд ЦДБЭЧ-д архивлагдан үлдэнэ.
- Уралдаанд шалгарсан бүтээлийн зохиогчтой ЦДБЭЧ гэрээ хийж, зохиогчийн эрхийг шилжүүлж хоёр тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

Шагнал: Уралдаанд шилдэг нэг бүтээлийг шалгаруулах бөгөөд 500.000 /Таван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналыг.

Дэлгэрэнгүй мэдээллийг: 8907-4727

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА